

МУИС-ийн БЭЛАС-ийн Удирдах
зөвлөлийн 2013.01 сарын 17
өдрийн хурлаар хэлэлцэж
батлав.

Дарга:
Доктор Г.Цагаач

**МУИС-ийн “Байгаль-Эх лицей” ахлах сургуулийн
“Сургууль хөгжүүлэх” сангийн дүрэм**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Тус сургуулийн дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулан, дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, сайн дурын болон ТББ-с /цаашид хандивлагч гэх/ санаачлан сайн дурын үндсэн дээр өгсөн хандив, буцалтгүй тусlamжийн орлогыг “Сургууль хөгжүүлэх сан”-д бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгах харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.
- 1.2. Сургуулийн өрдийн болон гүнзгийрүүлсэн сургалтын чанарыг сайжруулах орчныг хөгжүүлэх, хэтийн зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хандивлагчдаас санаачлан өгсөн хандив, буцалтгүй тусlamжийн мөнгөн орлого, эд зүйлсийн хуримтлалыг “Сургууль хөгжүүлэх сан” гэнэ.
- 1.3. Сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
 - 1.3.1. Хандивлагчаас өгсөн мөнгөн хөрөнгө
 - 1.3.2. Хандивлагчаас өгсөн тоног төхөөрөмж, бараа материал, бусад эд зүйлс.
 - 1.3.3. Хандивлагчаас өгсөн програм хангамж.
 - 1.3.4. Сангийн мөнгөн хөрөнгийн хадгаламжийн хүүгийн орлого.
- 1.4. Хандив, буцалтгүй тусlamжийг хандивлагч сайн дурын үндсэн дээр өгсөн байх бөгөөд нийтийг хамарсан албадлагын болон тэгшитгэн хураасан шинжгүй байна.

Хоёр. Санд хөрөнгө хүлээн авах

- 2.1. Сангийн хөрөнгийг хүлээн авах комиссыг сургуулийн захирал томилох бөгөөд уг комисс 7 хүний бүрэлдэхүүнтэй, дараах төлөөллөөс бүрдсэн байна.
Үүнд:
 1. Хичээлийн эрхлэгч-1
 2. Нягтлан бодогч-1
 3. Эцэг эхийн төлөөлөл - 2 /10, 11-р ангийн тус бүр 1/
 4. Багш, ажилтан тус бүр-1
 5. Суралцагч-1
- 2.2. Комиссыг 3 жилийн хугацаатай томилох бөгөөд эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтан, суралцагчийн төлөөллийг тухайн хамт олны хурлаас тус тус сонгоно.
- 2.3. Сангийн хөрөнгийг хариуцах хүнийг хамт олны саналыг үндэслэн захирал томилно.
- 2.4. Комисс хөрөнгийг санд хүлээн авч нягтлан бodoх бүртгэлийн анхан шатны бичиг баримтыг хөтлөн хандивлагчид албан баталгаа гаргаж өгнө.
- 2.5. Санд хандив оруулах санаачлагыг сургуулийн удирдах зөвлөл, сургуулийн хамт олны өргөтгөсөн хурлаар хэлэлцэн, тухайн хандивлах хөрөнгийн эх үүсвэрийн гарал үүсэл, хэмжээ нь Монгол улсын хууль, тогтоомжинд нийцэж буй эсэхийг судласны үндсэн дээр саналыг хүлээн авах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

- 2.6. Сургууль хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийг тусгай дансанд төвлөрүүлнэ.
- 2.7. Санд төвлөрсөн мөнгөн хөрөнгийг бэлнээр хадгалахыг хориглоно.
- 2.8. Сангийн хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, зарцуулалтыг захирал, нягтлан бодогч, сан хариуцсан хүн хариуцна.

Гурав. Сангийн хөрөнгийг зарцуулах

- 3.1. Сангийн хөрөнгийг дор дурьдсан ерөнхий чиглэлээр зарцуулна.
 - 3.1.1. сургуулийн номын санг баяжуулах,
 - 3.1.2. сургуулийн сургалтын орчин, нөхцөл сайжруулах ,
 - 3.1.3. сургалтын хэрэглэгдэхүүний хангалт, чанар, хүртээмжийг сайжруулах,
 - 3.1.4. багшлах боловсон хүчний чадамж, мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, ном товхитол хэвлүүлэх гэх мэт
- 3.2. Сангийн хөрөнгийг зарцуулах хөтөлбөр, төсөл, арга хэмжээ болон түүний төсвийг БЭЛАС-ийн удирдах зөвлөл батлан гаргана.
- 3.3. Сургуулийн удирдах зөвлөлийн гаргасан хөтөлбөр төсөл, арга хэмжээний төсөвт багтаан захирал сангийн хөрөнгийг зарцуулна.
- 3.4. Хандивлагчаас тодорхой нэр зааж хандивласан хөрөнгийг тухайн нэр заасан хамт олон болон суралцагчдад зориулна.
- 3.5. Сангийн хөрөнгөөс сургуулийн хэвийн үйл ажиллагааны урсгал зардал болон өр төлбөр барагдуулахад зарцуулахыг хориглоно.

Дөрөв. Сангийн хөрөнгийг тайлагнах

- 4.1. Сургууль нь сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын талаарх мэдээлэлийг нээлттэй байлгаж, олон нийтийн хяналт тавих нөхцөл бололцоог бүрдүүлсэн байна.
- 4.2. Сангийн хөрөнгийн зарцуулалтад сургуулийн удирдах зөвлөл, эцэг эх, асран хамгаалгчийн зөвлөл, сургуулийн хамт олон хяналт тавина.
- 4.3. Сургуулийн сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар эцэг эх, асран хамгаалагч болон сургуулийн хамт олонд улиралд нэг удаа захирал мэдээлэл хийнэ.
- 4.4. Сангийн хөрөнгийг сургуулийн нягтлан бodoх бүртгэлийн тайланда тусгах ба мэдээллийн бодитой, үнэн зөв эсэхийг сургуулийн захирал, нягтлан бодогч нар хариуцна.
- 4.5. Сангийн хөрөнгийн зарцуулалтын дэлгэрэнгүй тайланг хичээлийн жилийн болон санхүүгийн жилийн төгсгөлд гаргаж хандивлагчдад албан ёсоор хүргүүлж, удирдах зөвлөлд танилцуулна..

Тав. Хариуцлага

- 5.1. Энэхүү журмын 1.4- дэх заалтыг зөрчиж, сургууль өөрөө санаачлан нийтийг хамарсан албадлагын шинжтэй хандив, хуримтлалыг цуглуванс тохиолдолд буруутай албан тушаалтанд Боловсролын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.6-д заасан хариуцлагыг хүлээлгэнэ.
- 5.2. Сургуульд хандивласан хөрөнгийг санхүүгийн тайлан тэнцэлд тусгаагүй, түүнчлэн зориулалт бусаар зарцуулсан албан тушаалтанд Боловсролын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.9-д заасан хариуцлагыг хүлээлгэнэ.